



**ГАЛТ ТЭРЭГНИЙ
ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН
НЭГДСЭН ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2021 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/35.

Улаанбаатар хот

Зааварт нэмэлт оруулах тухай

Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн “Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 2 дугаар албан даалгаврын 1.5, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны “Цахим болон тоон гарын үсэгт шилжүүлэх тухай” А/160 дугаар тушаал, “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 6.9-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “ГТХЗНТ” УТҮГ-ын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 7.1.3, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны “Техник, технологийн шинэчлэлт, цахим шилжилтийн жил болгох зарлах тухай” А/01 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 16-д заасан арга хэмжээг төлөвлөсөн зорилтот түвшин, үр дүнд хүргэх, төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад мэдээ, баримт бичиг, албан хэрэг хөтлөлтийг тоон гарын үсэгт шилжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, тоон гарын үсгийн гэрчилгээтэй токен төхөөрөмжийн ашиглалтыг хэвшүүлэх зорилгоор төвийн захирлын 2021 оны А/17 дугаар тушаалаар баталсан “Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх, баримт бичгийг цахимаар солилцох заавар”-ын 2.1.3, 2.1.4, 2.2.3, 2.2.4, 2.4.4, 2.4.5, 2.5.1.9, 2.5.2.3, 2.5.2.5, 2.5.2.6, 2.5.2.15, 2.6.1.9, 2.8.1.2, 2.8.2.1, 2.8.2.2, 2.8.2.3, 2.8.2.4, 2.8.1.5.19, 2.9.1.2, 2.9.1.3, 2.9.1.4, 2.9.4.2, 2.9.4.3, 2.9.4.4, 2.9.6.1.1, 2.9.6.1.3, 2.9.6.1.4 дэх заалтын “цахим” гэсний дараа “болон тоон” гэж, 2.8.2.5, 2.9.4.5 дахь заалтын “нэгжийн даргын”, “холбогдох ажилтны” гэсний дараа “цахим болон тоон” гэж тус тус нэмсүгэй.

2. Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, төвийн албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд тоон гарын үсэг нэвтрүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулж, зааварчилгаа өгч ажиллахыг тоон гарын үсгийн чиг үүрэг хариуцсан ажилтан (Г.Баттөр)-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гэрчилгээжүүлэлт, хөдлөх бүрэлдэхүүн ашиглалт, бүртгэл мэдээллийн хэлтэс (Ц.Оюунбат)-т, “Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх, баримт бичгийг цахимаар солилцох заавар”-т орсон нэмэлтийг нийт ажилтанд танилцуулж мөрдүүлэхийг Захиргаа, санхүүгийн хэлтэс (И.Банзрагч)-т тус тус даалгасугай.

ЗАХИРАЛ



А.БУЯННЭМЭХ

000820